

**МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН 2017 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН
ШҮҮН ТАСЛАХ АЖИЛЛАГААНЫ МЭДЭЭ**


1. ХУРААНГУЙ.....	2
2. ЭРҮҮГИЙН ХЭРЭГ.....	5
2.1.1. ШҮҮН ТАСЛАХ БУСАД АЖИЛЛАГАА.....	8
3. ИРГЭНИЙ ХЭРЭГ.....	10
4. ЗАХИРГААНЫ ХЭРЭГ.....	14
5. ШҮҮГЧИЙН ХЭРГИЙН АЧААЛАЛ.....	17
6. ШҮҮХИЙН ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАХ АЖИЛЛАГАА.....	25
7. ШҮҮХИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ОРОЛЦОО.....	29
8. ДҮН ШИНЖИЛГЭЭ.....	32

1. ХУРААНГУЙ

а. Анхан шатны шүүх

Анхан шатны шүүх 2017 оны 1 дүгээр улиралд эрүүгийн 1667, иргэний 10331, захиргааны 425 хэргийг хянан шийдвэрлэсэн байна. Өмнөх оны 1 дүгээр улиралтай харьцуулбал хянан шийдвэрлэсэн иргэний хэрэг 302 буюу 3 хувиар, эрүүгийн хэрэг 180 буюу 12.1 хувиар, захиргааны хэрэг 78 буюу 22.5 хувиар тус тус өссөн байна. /График 1.1/

График-1.1



Шүүхэд нийт 238 хүнийг хорих ял эдлэхээс хугацааны өмнө тэнсэн суллах болон ялаас чөлөөлөх тухай санал, дүгнэлт ирүүлснээс 161 ялтныг хугацааны өмнө тэнсэн сулласан бол 7 ялтныг өвчний учир хугацаанаас өмнө хорих ял эдлэхээс чөлөөлж, 7 ялтны ял эдлэх дэглэмийг хүндрүүлж, 55 ялтны дэглэмийг бууруулж, 6 ялтанд холбогдох санал, дүгнэлтийг хэрэгсэхгүй болгож, 2 ялтны албадан ажил хийлгэх ялыг баривчлах ялаар сольж шийдвэрлэсэн байна. /График 1.2/

Шүүхээс нийт 1153 хүнд цагдан хорих арга хэмжээ авч, 79 хүнд цагдан хорих арга хэмжээ авахаас татгалзаж, 761 хүний цагдан хорих хугацааг сунгасан байна. /График 1.3/

График-1.2



График - 1.3



Мөн 2372 хүнийг захиргааны зөрчил үйлдсэн тул баривчилж, 389 хүнд торгох арга хэмжээ авч, 25 сая 18 мянга, 345 төгрөгийн торгууль ногдуулсан байна. /График 1.4/

График-1.4



б. Давж заалдах шатны шүүх:

- Эрүүгийн 491,
- Иргэний 1086
- Захиргааны 236, нийт 1813 хэрэг хянан шийдвэрлэсэн байна.

График-1.5



График-1.6



Давж заалдах шатны шүүхийн хянан шийдвэрлэсэн хэргийг өмнөх оны 1 дүгээр улиралтай харьцуулбал эрүүгийн хэрэг 60 буюу 13.9 хувиар, иргэний хэрэг 274 буюу 33.7 хувиар тус тус өссөн бол захиргааны хэрэг 119 буюу 33.5 хувиар буурсан байна. /График 1.6/

в. Хяналтын шатны шүүх:

- Эрүүгийн 67,
- Иргэний 336,
- Захиргааны 109, нийт 512 хэрэг хянан шийдвэрлэсэн байна.

2. ЭРҮҮГИЙН ХЭРЭГ

2.1 Анхан шатны шүүх

Анхан шатны шүүх 2017 оны 1 дүгээр улирлын байдлаар 1667 эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэж, тайлант хугацааны сүүлийн байдлаар¹ 633 хэргийн үлдэгдэлтэй байна. Үлдэгдэл хэргийн 5 хувь нь буюу 32 хэрэг хуулийн хугацаа хэтэрсэн байна.

Шүүхээр хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг өнгөрсөн оны мөн үеэс 12.1 хувиар, ял шийтгүүлэгчдийн тоо 10 хувиар тус тус өссөн байна.

Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс Төв аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, Дархан-Уул аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, Хөвсгөл аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг өндөр байгаа бол Говь-Алтай аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, Завхан аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, Сүхбаатар аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг харьцангуй цөөн байна.

Харин сум дундын шүүхүүдээс Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь сум дундын шүүхийн хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг хамгийн өндөр байгаа бол Хэнтий аймгийн Бор-Өндөр сум дахь сум дундын шүүхийн хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг харьцангуй цөөн байна.

Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн хувьд Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүдийн хянан шийдвэрлэсэн нийт хэргийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 47 хэргээр буюу 15.7 хувиар өссөн бол Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, Сонгинохайрхан дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүдийн нийт хянан шийдвэрлэсэн хэргийн тоо 6 хэргээр буюу 1.9 хувиар тус тус буурчээ. /Хүснэгт 2.1/

Хүснэгт 2.1

Анхан шатны шүүхийн хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг

№	Шүүх	Шийдвэрлэсэн хэрэг		№	Шүүх	Шийдвэрлэсэн хэрэг	
		2016 он 1-р улирал	2017 он 1-р улирал			2016 он 1-р улирал	2017 он 1-р улирал
1	Архангай аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	24	29	18	Увс аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	17	25
2	Баян-Өлгий аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	14	25	19	Ховд аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	20	19
3	Баянхонгор аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	57	49	20	Хөвсгөл аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	64	83

¹ 2016 оны 12 дугаар сарын 23-ны өдрөөс 2017 оны 03 дугаар сарын 23-ны өдрийг хүртэлх хугацааг тайлант хугацаа гэж ойлгоно.

4	Булган аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	43	42	21	Хэнтий аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	27	38
5	Говь-Алтай аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	14	14	22	Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүх	34	44
6	Говьсүмбэр аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	23	22	23	Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүх	8	7
7	Дархан-Уул аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	81	80	24	Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь сум дундын шүүх	13	20
8	Дорноговь аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	36	43	25	Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь сум дундын шүүх	17	17
9	Дорнод аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	27	34	26	Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь сум дундын шүүх	22	35
10	Дундговь аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	16	12	27	Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь сум дундын шүүх	13	14
11	Завхан аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	11	15	28	Ховд аймгийн Булган сум дахь сум дундын шүүх	9	17
12	Орхон аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	53	62	29	Хэнтий аймгийн Бор-Өндөр сум дахь сум дундын шүүх	5	6
13	Өмнөговь аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	18	28	30	Дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх /Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүрэг ² /	298	156 95 92
14	Өвөрхангай аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	27	52	31	Дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх /Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүрэг/	301	106 81 108
15	Сүхбаатар аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	21	18	32	Багануур дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	14	26

² 2016 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн “Шүүх байгуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуульд зааснаар Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх нь Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх болж тус тусдаа харьяалах нутаг дэвсгэрийн хэргийг хянан шийдвэрлэдэг болсон ч өмнөх онтой харьцуулах шаардлагатай тул дээрх 3 шүүхийн хянан шийдвэрлэсэн хэргийг нийлбэр дүнгээр тооцон гаргасан болно.

16	Сэлэнгэ аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	43	29	33	Багахангай, дүүргийн хэргийн анхан шүүх	Налайх Эрүүгийн анхан шатны	14	27
17	Төв аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	103	97	34	Бүгд		1487	1667

Шийдвэрлэсэн зарим төрлийн хэрэг. Тайлангийн хугацаанд хүнийг санаатай алах гэмт хэрэг 2 хэргээр буюу 3.4 хувиар, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй ажиллагааны журам зөрчсөн гэмт хэрэг 19 хэргээр буюу 9.8 хувиар, бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг 51 хэргээр буюу 18.3 хувиар, танхайрах гэмт хэрэг 30 хэргээр буюу 20.7 хувиар, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэг 12 хэргээр буюу 30.8 хувиар тус тус өссөн бол хүчиндэх гэмт хэрэг 1 хэргээр буюу 1.8 хувиар, бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулах гэмт хэрэг 12 хэргээр буюу 11.8 хувиар, эд зүйлсийг хууль бусаар хил нэвтрүүлэх гэмт хэрэг 2 хэргээр буюу 28.6 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй гарсан байна. /Хүснэгт 2.2/


Хүснэгт 2.2

Хянан шийдвэрлэсэн зарим гэмт хэрэг

№	Үзүүлэлт	2016 он I улирал	2017 он I улирал	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь
1	Хүнийг санаатай алах	58	60	2	3.4
2	Бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулах	102	90	-12	-11.8
3	Хүчиндэх	55	54	-1	-1.8
4	Бусдын эд хөрөнгийг хулгайлах	278	329	51	18.3
5	Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх	39	51	12	30.8
6	Танхайрах	145	175	30	20.7
7	ТХХАБАЖ Зөрчсөн	194	213	19	9.8
8	Эд зүйлсийг хууль бусаар хил нэвтрүүлэх	7	5	-2	-28.6
9	Бусад	609	690	81	13.3
10	НИЙТ	1487	1667	180	12.1

Хянан шийдвэрлэсэн зарим төрлийн хэргийг нийт хянан шийдвэрлэсэн хэрэгт эзлэх хувиар нь авч үзвэл нийт шийдвэрлэсэн хэргийн 19.7 хувийг бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг, 12.8 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг, 10.5 хувийг танхайрах гэмт хэрэг эзэлж байна. /График 2.1/

График-2.1



2017 оны 1 дүгээр улирлын байдлаар гэмт хэргийн улмаас нийтдээ 6 тэрбум 865 сая 550 мянга 926 төгрөгийн эд хөрөнгийн хохирол учирч, 154 хүний амь нас хохирч, 169 хүний биед хүнд гэмтэл учирчээ.

Анхан шатны шүүхээр нийт 1914 хүн ял шийтгүүлснээс 78.5 хувь буюу 1503 хүнд хорих ял, 3.8 хувь буюу 72 хүнд торгох ял, 5.6 хувь буюу 107 хүнд албадан ажил хийлгэх ял, 10.3 хувь буюу 197 хүнд баривчлах ял тус тус оногдуулж, насанд хүрээгүй 34 этгээдэд хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ, 1 хүнд эмнэлэгийн чанартай албадлагын арга хэмжээ авсан байна. Хорих ял оногдуулсан 1503 хүнээс 34.8 хувьд нь буюу 523 хүний хорих ялыг биечлэн эдлүүлэхээр шийдвэрлэжээ. Хорих ял шийтгүүлсэн хүний тоо өмнөх оны 1 дүгээр улиралтай харьцуулбал 15.3 хувиар, торгох ял шийтгүүлсэн хүний тоо 26.3 хувиар, албадан ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн хүний тоо 0.9 хувиар тус тус өссөн бол баривчлах ял шийтгүүлсэн хүний тоо 21.2 хувиар тус тус буурсан байна.

Нийт ял шийтгүүлэгчдийн дотор 9.4 хувь буюу 179 нь эмэгтэйчүүд, 6.9 хувь буюу 128 нь насанд хүрээгүй хүмүүс байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал ял шийтгүүлсэн эмэгтэйчүүдийн тоо 1.6 дахин, насанд хүрээгүй хүний тоо 1.5 дахин тус тус өсжээ.

2.1.1. ШҮҮН ТАСЛАХ БУСАД АЖИЛЛАГАА

Улсын хэмжээнд 2017 оны 1 дүгээр улирлын байдлаар шүүхээс нийт 93 сэжигтнийг баривчлах зөвшөөрөл олгож, 9 сэжигтнийг баривчлах зөвшөөрөл олгохоос татгалзаж, 24 сэжигтнийг суллажээ. Өмнөх оны 1 дүгээр улиралтай харьцуулбал баривчлах зөвшөөрөл олгосон хүний тоо 54.4 хувиар, сулласан хүний тоо 31.4 хувиар тус тус буурсан бол, татгалзсан хүний тоо 1.5 дахин өссөн байна.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 68 дугаар зүйлд зааснаар 1153 хүнийг сэжигтэн, яллагдагчаар цагдан хорьж, 79 хүнд цагдан хорих зөвшөөрөл олгохоос татгалзаж, 761 сэжигтэн, яллагдагчийн цагдан хорьж мөрдөх хугацааг сунгасан байна. Өмнөх оны 1 дүгээр улиралтай харьцуулбал цагдан хорих зөвшөөрөл олгохоос татгалзсан хүний тоо 12 буюу 17.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна. /График 2.2/

График 2.2



Тайлант хугацаанд 238 хүнийг хорих ял эдлэхээс хугацааны өмнө тэнсэн суллах, ялаас чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэж, 161 ялтныг ялаас хугацааны өмнө тэнсэн суллаж, 7 ялтныг өвчний учир хугацаанаас өмнө ял эдлэхээс чөлөөлж, 6 санал, дүгнэлтийг хэрэгсэхгүй болгож, 2 ялтанд албадан ажил хийлгэх ялыг баривчлах ялаар сольж шийдвэрлэсэн байна. Түүнчлэн 7 ялтны ял эдлэх дэглэмийг хүндрүүлж, 55 ялтны дэглэмийг бууруулжээ.

Улсын хэмжээнд захиргааны зөрчил үйлдсэний улмаас шүүхээс 389 хүнийг 25 сая 018 мянга 345 төгрөгөөр торгож, 2372 хүнд баривчлах захиргааны шийтгэл ногдуулсан байна.

2.2 Давж заалдах шатны шүүх

Давж заалдах шатны шүүх эрүүгийн нийт 491 хэргийг хянан шийдвэрлэж, үүнээс 45.8 хувьд нь буюу 225 хэрэгт анхан шатны шүүхийн тогтоолыг хэвээр үлдээж, 18.4 хувь буюу 90 хэргийг тогтоолд өөрчлөлт оруулж, 35.8 хувь буюу 176 хэргийн тогтоолыг хүчингүй болгож шийдвэрлэсэн байна. /График-2.3/

График-2.3



Давж заалдах шатанд анхан шатны шүүхийн тогтоолыг хэвээр үлдээсэн магадлалын эзлэх хэмжээ өмнөх оны 1 дүгээр улиралтай харьцуулбал 5.7 хувиар өссөн бол, өөрчлөлт оруулсан магадлалын эзлэх хэмжээ 5.5 хувиар, хүчингүй болгож шийдвэрлэсэн магадлалын эзлэх хэмжээ 0.4 хувиар тус тус буурсан нь эерэг үзүүлэлт байна. /Хүснэгт -2.3/


Хүснэгт 2.3

№	Шийдвэрлэсэн хэрэг	2016 он I улирал	Эзлэх хувь	2017 он I улирал	Эзлэх хувь	Өсөлт, бууралт
1	Хэвээр үлдээсэн	173	40.1	225	45.8	5.7
2	Өөрчлөлт оруулсан	102	23.7	90	18.4	-5.5
3	Хүчингүй болгосон	156	36.2	176	35.8	-0.4

2.3 Хяналтын шатны шүүх

Хяналтын шатны журмаар нийт 67 эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэснээс 55.2 хувь буюу 37 хэрэгт шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж, 34.3 хувь буюу 23 хэргийн шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулж, 10.5 хувь буюу 7 хэргийн шийдвэрийг хүчингүй болгож шийдвэрлэсэн байна. /График 2.4/

График-2.4



Хяналтын шатны шүүхээс шүүхийн тогтоол, магадлалыг хэвээр үлдээсэн шийдвэрийн эзлэх хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 5.8 хувиар, тогтоолыг хүчингүй болгож шийдвэрлэсэн магадлалын эзлэх хэмжээ 12.9 хувиар тус тус буурсан бол өөрчлөлт оруулсан магадлалын эзлэх хэмжээ 7.1 хувиар өссөн байна. /Хүснэгт 2.4/

Хүснэгт 2.4

№	Шийдвэрлэсэн хэрэг	2016 он I улирал	Эзлэх хувь	2017 он I улирал	Эзлэх хувь	Өсөлт, бууралт
1	Хэвээр үлдээсэн	40	49.4	37	55.2	5.8
2	Өөрчлөлт оруулсан	22	27.2	23	34.3	7.1
3	Хүчингүй болгосон	19	23.4	7	10.5	-12.9

3. ИРГЭНИЙ ХЭРЭГ

3.1 Анхан шатны шүүх

Анхан шатны шүүх нийт 2017 оны 1 дүгээр улирлын байдлаар 10331 иргэний хэрэг хянан шийдвэрлэж, үүнээс 3984 хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэжээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулан үзвэл хянан шийдвэрлэсэн иргэний хэрэг 302 хэргээр буюу 3 хувиар өсчээ. Анхан шатны шүүхэд нийт 6265 иргэний хэргийн үлдэгдэл байгаагаас 10.5 хувь буюу 661 хэргийн хуулийн хугацаа хэтэрсэн байна.

Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхээс Дархан-Уул аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх, Орхон аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны

шүүх, Хөвсгөл аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх, Дорнод аймаг дахь иргэний хэргийн анхан шатны шүүхийн хянан шийдвэрлэсэн иргэний хэргийн тоо өндөр байгаа бол Говьсүмбэр аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн хэргийн тоо харьцангуй цөөн байна.

Харин Сум дундын шүүхүүдийн хувьд Дорноговь аймгийн Замын-үүд сум дахь сум дундын шүүхийн шийдвэрлэсэн хэрэг өндөр байгаа бол Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь сум дундын шүүхийн хянан шийдвэрлэсэн хэрэг дунджаас харьцангуй цөөн байна.

Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхүүдийн хувьд Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх, Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн хянан шийдвэрлэсэн нийт хэргийн тоо 4 хэргээр буюу 0.1 хувиар өссөн бол Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх, Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн нийт хэргийн тоо 95 хэргээр буюу 3.5 хувиар буурсан байна. /Хүснэгт 3.1/

Хүснэгт 3.1

Анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн иргэний хэрэг

№	Шүүх	Шийдвэрлэсэн хэрэг		№	Шүүх	Шийдвэрлэсэн хэрэг	
		2016 он 1-р улирал	2017 он 1-р улирал			2016 он 1-р улирал	2017 он 1-р улирал
1	Архангай аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	166	148	18	Увс аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	204	264
2	Баян-Өлгий аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	182	207	19	Ховд аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	144	151
3	Баянхонгор аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	193	234	20	Хөвсгөл аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	380	352
4	Булган аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	126	131	21	Хэнтий аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	190	191
5	Говь-Алтай аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	97	120	22	Дорноговь аймгийн Замын-үүд сум дахь сум дундын шүүх	77	139
6	Говьсүмбэр аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	42	54	23	Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүх	59	58
7	Дархан-Уул аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	437	389	24	Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь сум дундын шүүх	43	26

8	Дорноговь аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	105	113	25	Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь сум дундын шүүх	74	111
9	Дорнод аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	329	335	26	Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь сум дундын шүүх	77	117
10	Дундговь аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	74	110	27	Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь сум дундын шүүх	114	77
11	Завхан аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	92	144	28	Ховд аймгийн Булган сум дахь сум дундын шүүх	50	34
12	Орхон аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	372	351	29	Хэнтий аймгийн Бор-Өндөр сум дахь сум дундын шүүх	67	47
13	Өмнөговь аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	156	122	30	Дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх /Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүрэг ³ /	2488	1033 850 609
14	Өвөрхангай аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	97	139	31	Дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх /Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүрэг/	2807	1019 837 856
15	Сүхбаатар аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	98	134	32	Багануур дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	129	120
16	Сэлэнгэ аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	179	248	33	Багахангай, Налайх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	154	183
17	Төв аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	227	278	34	Бүгд	10029	10331

3.2 Давж заалдах шатны шүүх

Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх иргэний 1086 хэргийг хянан хэлэлцэж, анхан шатны шүүхийн 401 шийдвэр буюу 36.9 хувийг хэвээр үлдээж, 358 шийдвэр буюу 32.9 хувьд өөрчлөлт оруулж, 327 шийдвэр буюу 30.2 хувийг хүчингүй болгож шийдвэрлэсэн байна. Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх нийт хэргийн шийдвэрийг өөрчилж, хүчингүй болгосон нь нийт магадлалын 63.1 хувийг эзэлж байна.

³ 2016 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн “Шүүх байгуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуульд зааснаар Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх нь Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх, Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх болж тус тусдаа харьяалах нутаг дэвсгэрийн хэргийг хянан шийдвэрлэдэг болсон ч өмнөх онтой харьцуулах шаардлагатай тул дээрх 3 шүүхийн хянан шийдвэрлэсэн хэргийн нийлбэр дүнгээр тооцон гаргасан болно.

График-3.1



Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн магадлалын эзлэх хэмжээ өмнөх оны мөн үеэс 1.9 хувиар буурсан бол өөрчлөлт оруулсан магадлалын эзлэх хэмжээ 0.4 хувиар, хүчингүй болгож шийдвэрлэсэн магадлалын эзлэх хэмжээ 1.5 хувиар тус тус өссөн байна. /Хүснэгт 3.2/

Хүснэгт 3.2

№	Шийдвэрлэсэн хэрэг	2016 он I улирал	Эзлэх хувь	2017 он I улирал	Эзлэх хувь	Өсөлт, бууралт
1	Хэвээр үлдээсэн	315	38.8	401	36.9	-1.9
2	Өөрчлөлт оруулсан	264	32.5	358	32.9	0.4
3	Хүчингүй болгосон	233	28.7	327	30.2	1.5

3.3 Хяналтын шатны шүүх

Хяналтын шатны шүүх нийт 336 иргэний хэргийг хянан шийдвэрлэснээс 173 хэрэгт буюу 51.5 хувьд нь шийдвэрийг хэвээр үлдээж, 64 хэрэгт буюу 19 хувьд нь шийдвэрт өөрчлөлт оруулж, 99 хэрэгт буюу 29.5 хувьд нь шийдвэр, магадлалыг хүчингүй болгосон байна. /График 3.2/

График-3.2



Хяналтын шатны шүүхээс шүүхийн шийдвэр, магадлалыг хэвээр үлдээсэн шийдвэрийн эзлэх хэмжээ 1.6 хувиар, өөрчлөлт оруулсан тогтоолын эзлэх хэмжээ 2.7 хувиар тус тус буурсан бол хүчингүй болгож шийдвэрлэсэн тогтоолын эзлэх хэмжээ 4.3 хувиар өссөн нь иргэний хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийн тогтвортой байдалд анхаарах шаардлагатай болсоныг харуулж байна. /Хүснэгт 3.3/

Хүснэгт 3.3

№	Шийдвэрлэсэн хэрэг	2016 он I улирал	Эзлэх хувь	2017 он I улирал	Эзлэх хувь	Өсөлт, бууралт
1	Хэвээр үлдээсэн	154	53.1	173	51.5	-1.6
2	Өөрчлөлт оруулсан	63	21.7	64	19	-2.7
3	Хүчингүй болгосон	73	25.2	99	29.5	4.3

4. ЗАХИРГААНЫ ХЭРЭГ

4.1 Анхан шатны шүүх

Захиргааны хэргийн анхан шатны шүүхүүд 2017 оны 1 дүгээр улирлын байдлаар 425 хэргийг хянан шийдвэрлэсэн бөгөөд үүнээс 116 хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн байна. Хянан шийдвэрлэсэн захиргааны хэрэг өмнөх оны мөн үеэс 78 хэргээр буюу 22.5 хувиар өсчээ. Тайлант хугацааны эцсийн байдлаар нийт 753 хэргийн үлдэгдэлтэй байгаагаас хуулийн хугацаа хэтэрсэн үлдэгдэл хэрэг 101 байна.

Орон нутаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхүүдээс Дархан-Уул аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн хэргийн тоо харьцангуй өндөр байна. Улсын хэмжээнд анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн захиргааны хэргийн 48.7 хувийг Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх шийдвэрлэжээ. /Хүснэгт 4.1/

Хүснэгт 4.1

Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн хэрэг

№	Шүүх	Захиргааны хэрэг		№	Шүүх	Захиргааны хэрэг	
		2016 он I улирал	2017 он I улирал			2016 он I улирал	2017 он I улирал
1	Архангай аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	8	16	12	Дундговь аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	3	11
2	Баян-Өлгий аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	7	23	13	Завхан аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	7	19
3	Баянхонгор аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	10	6	14	Өмнөговь аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	5	5
4	Булган аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	6	9	15	Өвөрхангай аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	9	7
5	Орхон аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	5	8	16	Сүхбаатар аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	5	4
6	Говь-алтай аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	8	9	17	Төв аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	6	6

7	Говьсүмбэр аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	2	2	18	Увс аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	10	17
8	Дархан-Уул аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	16	37	19	Ховд аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	12	5
9	Сэлэнгэ аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	2	9	20	Хөвсгөл аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	8	11
10	Дорноговь аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	5	6	21	Хэнтий аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	3	5
11	Дорнод аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	8	3	22	Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх	202	207
23	Нийт					347	425

4.2 Давж заалдах шатны шүүх

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх нийт 236 хэргийг хянан шийдвэрлэсэн байна. Хянан шийдвэрлэсэн нийт хэргийн 38.5 хувь буюу 91 хэрэгт анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж, 26.3 хувь буюу 62 хэрэгт шийдвэрт өөрчлөлт оруулж, 35.2 хувь буюу 83 хэрэгт шийдвэрийг хүчингүй болгожээ. /График 4.1/

График-4.1



Давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн магадлалын эзлэх хэмжээ өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 6.5 хувиар буурсан бол өөрчлөлт оруулсан магадлалын эзлэх хэмжээ 4.3 хувиар, хүчингүй болгосон магадлалын эзлэх хэмжээ 2.2 хувиар өссөн нь сөрөг үр дүнтэй байна. /Хүснэгт 4.2/

Хүснэгт 4.2

№	Шийдвэрлэсэн хэрэг	2016 он I улирал	Эзлэх хувь	2017 он I улирал	Эзлэх хувь	Өсөлт, бууралт
1	Хэвээр үлдээсэн	160	45.0	91	38.5	-6.5
2	Өөрчлөлт оруулсан	78	22.0	62	26.3	4.3
3	Хүчингүй болгосон	117	33.0	83	35.2	2.2

4.3 Хяналтын шатны шүүх

Хяналтын шатны шүүх захиргааны нийт 109 хэргийг хянан шийдвэрлэснээс 56 хувь буюу 61 хэрэгт шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж, 12 хувь буюу 13 хэрэгт шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулж, 32 хувь буюу 35 хэрэгт шийдвэр, магадлалыг хүчингүй болгож шийдвэрлэжээ. /График 4.2/

График-4.2



Хяналтын шатны шүүхээс шүүхийн шийдвэр, магадлалыг хэвээр үлдээсэн шийдвэрийн эзлэх хэмжээ өмнөх оны мөн үеэс 8.6 хувиар, өөрчлөлт оруулсан шийдвэрийн эзлэх хэмжээ 8.8 хувиар тус тус буурсан бол хүчингүй болгосон шийдвэрийн эзлэх хэмжээ 17.4 хувиар өссөн байгаа нь захиргааны хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийн тогтвортой байдалд нэн анхаарах шаардлагатай болсоныг харуулж байна. Үүнтэй холбоотойгоор захиргааны хэргийн давж заалдах болон хяналтын шатны шүүхээр өөрчлөлт оруулсан, хүчингүй болгож шийдвэрлэсэн магадлал, тогтоолыг судлан шинжилсэний үндсэн дээр үр дүнтэй сургалтыг зохион байгуулах нь зүйтэй гэж үзэж байна. /Хүснэгт 4.3/

Хүснэгт 4.3

№	Шийдвэрлэсэн хэрэг	2016 он I улирал	Эзлэх хувь	2017 он I улирал	Эзлэх хувь	Өсөлт, бууралт
1.	Хэвээр үлдээсэн	62	64.6	61	56	-8.6
2.	Өөрчлөлт оруулсан	20	20.8	13	12	-8.8
3.	Хүчингүй болгосон	14	14.6	35	32	17.4

5. ШҮҮГЧИЙН ХЭРГИЙН АЧААЛАЛ

5.1 Анхан шатны шүүх

Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх: Шүүгчийн хэргийн ачааллыг тооцохдоо тухайн шүүхийн хянан шийдвэрлэсэн нийт хэргийг тайлант хугацаанд ажилласан шүүгчийн тоонд харьцуулж гаргав.⁴ 2017 оны 1 дүгээр улирлын байдлаар Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүдэд нийт 55 шүүгч ажилласан бөгөөд нэг шүүгчид дунджаар 11.9 хэрэг ногдож байна. /Хүснэгт 5.1/

Хүснэгт 5.1.

Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн хэргийн ачаалал

№	Шүүх	Эрүүгийн хэрэг	Шүүгчдийн тоо	Нэг шүүгчид ногдох хэргийн тоо
1	Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	156	9	17.3
2	Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	95	7	13.5
3	Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	92	7	13.1
4	Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	106	8	13.3
5	Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	81	7	11.6
6	Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	108	10	10.8
7	Багануур дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	26	4	6.5
8	Багахангай, Налайх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	27	3	9
9	Нийт	691	55	11.9

Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх: Тайлант хугацаанд Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхүүдэд нийт 83.7 шүүгч ажилласан бөгөөд нэг шүүгчид дунджаар 65.8 хэрэг ногдож байна. Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх, Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн хэргийн ачаалал хамгийн их байгаа бол Багануур дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн ачаалал дунджаас харьцангуй бага байна. /Хүснэгт 5.2/

Хүснэгт 5.2.

Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн хэргийн ачаалал

№	Шүүх	Эрүүгийн хэрэг	Шүүгчдийн тоо	Нэг шүүгчид ногдох хэргийн тоо
1	Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	1033	16	64.5

⁴ Тайлант хугацаанд ажилласан шүүгчдийн тоог тооцохдоо Шүүхийн хүний нөөцийн газраас гаргасан тоон судалгаан дээр үндэслэсэн болно. Тухайлбал, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх 1, 3 дугаар саруудад 12 шүүгчтэй, 2 дугаар сард 11 шүүгчтэй ажилласан байна. Эндээс 11 шүүгч нь тайлант хугацаанд бүтэн 3 сар ажилласан бол 1 шүүгч нь 2 сар ажилласан гэж тооцвол нийт шүүгчдийн дундаж тоо 11.5 байна. Өөрөөр хэлбэл, 1 шүүгч тайлант хугацааны 3 сар бүтэн ажилласан бол “1 бүхэл” гэж тооцогдох бөгөөд шинэ шүүгч томилогдсон тохиолдолд 1/3*ажилласан сар гэсэн аргачлалаар тооцсон болно.

2	Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	850	11	77.3
3	Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	609	11.9	51.1
4	Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	1019	14	72.7
5	Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	837	11	76
6	Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	856	11.5	74.4
7	Багануур дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	120	4	30
8	Багахангай, Налайх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	183	4.3	72.5
9	Нийт	5507	83.7	65.8

Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх: Тайлант хугацаанд сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд 69.3 шүүгч ажилласан бол нэг шүүгчид дунджаар 11.7 хэрэг ногдож байна. Төв аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд нэг шүүгчид 19.4 хэрэг, Орхон аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд нэг шүүгчид 20.6 хэрэг, Хөвсгөл аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд нэг шүүгчид 20.7 хэрэг ногдож байгаа нь дунджаас харьцангуй их байна. Дундговь аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд нэг шүүгч дунджаар 4 хэрэг, Говь-Алтай аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд нэг шүүгч дунджаар 4.6 хэрэг шийдвэрлэсэн нь харьцангуй бага байгааг харуулж байна. /Хүснэгт 5.3/

Хүснэгт 5.3.

Сум дундын эрүүгийн шүүхийн шүүгчийн хэргийн ачаалал

№	Шүүх	Эрүүгийн хэрэг	Шүүгчдийн тоо	Нэг шүүгчид ногдох хэргийн тоо
1	Архангай аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	29	3	9.6
2	Баян-Өлгий аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	25	2	12.5
3	Баянхонгор аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	49	4	12.2
4	Булган аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	42	3	14
5	Говь-Алтай аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	14	3	4.6
6	Говьсүмбэр аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	22	3.3	6.6
7	Дархан-Уул аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	80	5	16
8	Дорноговь аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	43	3	14.3
9	Дорнод аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	34	4	8.5

10	Дундговь аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	12	3	4
11	Завхан аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	15	3	5
12	Орхон аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	62	3	20.6
13	Өмнөговь аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	28	3	9.3
14	Өвөрхангай аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	52	3	17.3
15	Сүхбаатар аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	18	3	6
16	Сэлэнгэ аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	29	3	9.6
17	Төв аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	97	5	19.4
18	Увс аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	25	3	8.3
19	Ховд аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	19	3	6.3
20	Хөвсгөл аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	83	4	20.7
21	Хэнтий аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	38	3	12.6
22	Нийт	816	69.3	11.7

Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх: Тайлант хугацаанд сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд 71.2 шүүгч ажилласан бол нэг шүүгчид дунджаар 59.2 хэрэг ногдож байна. Дархан-Уул аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэг шүүгчид 77.8 хэрэг, Баянхонгор аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэг шүүгчид 78 хэрэг, Увс аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэг шүүгчид 88 хэрэг ногдож байгаа нь дунджаас харьцангуй их байна. Говьсүмбэр аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэг шүүгч дунджаар 23.5 хэрэг, Дундговь аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэг шүүгч дунджаар 36.7 хэрэг, Дорноговь аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх 37.7 хэрэг шийдвэрлэсэн нь харьцангуй бага байгааг харуулж байна. /Хүснэгт 5.4/

Хүснэгт 5.4.

Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн хэргийн ачаалал

№	Шүүх	Иргэний хэрэг	Шүүгчдийн тоо	Нэг шүүгчид ногдох хэргийн тоо
1	Архангай аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	148	2.6	56.9
2	Баян-Өлгий аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	207	4	51.8
3	Баянхонгор аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	234	3	78.0
4	Булган аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	131	3	43.7
5	Говь-Алтай аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	120	3	40.0
6	Говьсүмбэр аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	54	2.3	23.5
7	Дархан-Уул аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	389	5	77.8
8	Дорноговь аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	113	3	37.7
9	Дорнод аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	335	5	67.0
10	Дундговь аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	110	3	36.7
11	Завхан аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	144	3	48.0
12	Орхон аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	351	5	70.2
13	Өмнөговь аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	122	3	40.7
14	Өвөрхангай аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	139	2.3	60.4
15	Сүхбаатар аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	134	3	44.7
16	Сэлэнгэ аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	248	4	62.0
17	Төв аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	278	4	69.5
18	Увс аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	264	3	88.0
19	Ховд аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	151	2	75.5
20	Хөвсгөл аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	352	5	70.4
21	Хэнтий аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	191	3	63.7
22	Нийт	4215	71.2	59.2

Сум дундын шүүх: Сум дундын шүүхийн хувьд 2017 оны 1 дүгээр улирлын байдлаар нэг шүүгчид дунджаар 21.9 хэрэг ногдож байгаа бол Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь сум дундын шүүх (50.7 хэрэг), Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүх (45.8 хэрэг) шийдвэрлэсэн нь дунджаас харьцангуй их ачаалалтай байна. Харин Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь сум дундын шүүх (15.3 хэрэг), Хэнтий аймгийн Бор-Өндөр сум дахь сум дундын шүүх (13.3 хэрэг) шийдвэрлэсэн нь дунджаас харьцангуй бага байгааг харуулж байна.

Хүснэгт 5.5.

Сум дундын шүүхийн шүүгчийн хэргийн ачаалал

№	Шүүх	Эрүүгийн хэрэг	Иргэний хэрэг	Нийт хэрэг	Шүүгчдийн тоо	Нэг шүүгчид ногдох хэргийн тоо
1	Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүх	44	139	183	4	45.8
2	Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүх	7	58	65	4	16.3
3	Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь сум дундын шүүх	20	26	46	3	15.3
4	Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь сум дундын шүүх	17	111	128	4	32.0
5	Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь сум дундын шүүх	35	117	152	3	50.7
6	Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь сум дундын шүүх	14	77	91	4	22.8
7	Ховд аймгийн Булган сум дахь сум дундын шүүх	17	34	51	3	17.0
8	Хэнтий аймгийн Бор-Өндөр сум дахь сум дундын шүүх	6	47	53	4	13.3
9	Нийт	160	609	769	35	21.97

Захиргааны хэргийн анхан шатны шүүх: Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд 2017 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт 77 шүүгч ажилласан бөгөөд нэг шүүгчид дунджаар 5.5 хэрэг ногдож байна. Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн нэг шүүгч дунджаар 9.9 хэрэг хянан шийдвэрлэсэн нь улсын хэмжээний дунджаас 1.8 дахин, Дархан-Уул аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн нэг шүүгч дунджаар 12.3 хэрэг хянан шийдвэрлэсэн нь улсын дунджаас 2.2 дахин их байна.

Хүснэгт 5.6.

Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн хэргийн ачаалал

№	Шүүх	Захиргааны хэрэг	Шүүгчдийн тоо	Нэг шүүгчид ногдох хэрэг
1	Архангай аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	16	2	8.0
2	Баян-Өлгий аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	23	3	7.7
3	Баянхонгор аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	6	3	2.0
4	Булган аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	9	3	3.0

5	Говь-Алтай аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	9	2	4.5
6	Говьсүмбэр аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	2	2	1.0
7	Дархан-Уул аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	37	3	12.3
8	Дорноговь аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	6	3	2.0
9	Дорнод аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	3	3	1.0
10	Дундговь аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	11	2	5.5
11	Завхан аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	19	3	6.3
12	Орхон аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	8	3	2.7
13	Өмнөговь аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	5	2	2.5
14	Өвөрхангай аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	7	3	2.3
15	Сүхбаатар аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	4	3	1.3
16	Сэлэнгэ аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	9	3	3.0
17	Төв аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	6	3	2.0
18	Увс аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	17	3	5.7
19	Ховд аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	5	2	2.5
20	Хөвсгөл аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	11	2	5.5
21	Хэнтий аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	5	3	1.7
22	Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх	207	21	9.9
23	Нийт	425	77	5.5

Дорнод болон Хэнтий аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд нэг шүүгчид тус бүр 1.0-1.3 хэрэг ногдож байгаа нь хамгийн бага байна.

5.1.1 Давж заалдах шатны шүүх

Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн ачаалал⁵: Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхэд 2017 оны байдлаар нийт 96.2 шүүгч ажилласан бол нэг шүүгчид

⁵ 2016 оны 06 дугаар сарын 01-ний өдөр хэрэгжиж эхэлсэн “Шүүх байгуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль”-д зааснаар Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийг нэгтгэн 1 шүүх гэж үздэг болсон тул тухайн

дунджаар 16.4 хэрэг ногдож байна. Нийслэлийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн нэг шүүгч дунджаар 34 хэрэг шийдвэрлэсэн байгаа нь хамгийн өндөр байна. Орхон аймгийн Эрүү, Иргэний⁶ хэргийн давж заалдах шатны шүүхийн нэг шүүгчид дунджаар 19 хэрэг, Сэлэнгэ аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн нэг шүүгчид дунджаар 12.3 хэрэг шийдвэрлэсэн нь орон нутгийн давж заалдах шатны шүүхүүдээс хамгийн өндөр байна. Харин Сүхбаатар аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн нэг шүүгчид дунджаар 0.5 хэрэг шийдвэрлэсэн нь дунджаас харьцангуй бага байна.

Хүснэгт 5.7.

Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн хэргийн ачаалал

№	Шүүх	Эрүүгийн хэрэг	Иргэний хэрэг	Нийт хэрэг	Шүүгчдийн тоо	Нэг шүүгчид ногдох хэрэг
1	Архангай Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	10	4	14	2.6	5.4
2	Баян-Өлгий аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	9	28	37	3	12.3
3	Баянхонгор аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	14	8	22	2	11.0
4	Булган Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	6	3	9	3	3.0
5	Говь-Алтай аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	6	13	19	3	6.3
6	Говьсүмбэр аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	0	3	3	2.6	1.2
7	Дархан-Уул аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	21		21	3	7
8	Дархан-Уул аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх		51	51	4	12.7
9	Дорноговь аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	21	5	26	3	8.7
10	Дорнод аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	22	13	35	3	11.7
11	Дундговь аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	6	6	12	3	4.0
12	Завхан аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	8	4	12	3	4.0
13	Орхон аймгийн Эрүү хэргийн давж заалдах шатны шүүх	45		45	3	15.0
14	Орхон аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх		69	69	3	23.0

шүүхэд хянан шийдвэрлэсэн эрүү, иргэний хэргийн нийлбэрийг нийт ажиллаж буй шүүгчийн тоонд харьцуулж шүүгчийн хэргийн ачааллыг тооцон гаргасан болно.

⁶ 2016 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн “Шүүх байгуулах тухай” хуульд зааснаар 21 аймагт давж заалдах шатны шүүхийг Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх болгон хамтатган заасан боловч Дархан-Уул болон Орхон аймгуудад Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхүүдийг тусад байгуулсан болно.

15	Өмнөговь аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	15	12	27	3	9.0
16	Өвөрхангай аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	14	10	24	2.6	9.2
17	Сүхбаатар аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	0	1	1	2	0.5
18	Сэлэнгэ аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	25	12	37	3	12.3
19	Төв аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	19	7	26	4	6.5
20	Увс аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	5	14	19	2	9.5
21	Ховд аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	13	10	23	3	7.7
22	Хөвсгөл аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	6	14	20	3	6.7
23	Хэнтий аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	20	4	24	3	8.0
24	Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх, Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	206	795	1001	29.4	34.0
25	Нийт	491	1086	1577	96.2	16.4

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх: Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд 11 шүүгч ажиллаж байна. 2017 оны 1 дүгээр улирлын байдлаар тус шүүх 236 хэрэг хянан шийдвэрлэсэн бөгөөд нэг шүүгчид 21.4 хэрэг ногдож байна.

6. ШҮҮХИЙН ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАХ АЖИЛЛАГАА


Иргэний хэргийн анхан шатны шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчид 2017 оны нэгдүгээр улиралд шүүхийн бус журмаар маргаанаа шийдвэрлүүлэхээр нийт 4323 нэхэмжлэл, хүсэлт, өргөдөл хүлээн авчээ. Үүнээс шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчид 4190 өргөдөл, 131 нь шүүхээс иргэний хэрэг үүсгэсний дараа шилжүүлэн ирсэн иргэний хэрэг, 2 нь шүүхээс иргэний хэрэг үүсгэхээс өмнө шилжүүлэн ирсэн нэхэмжлэл байна.

Шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчид гаргасан 4190 өргөдлийн 202 буюу 4.8 хувийг хүлээн авахаас татгалзаж, 160 буюу 3.8 хувийг хүсэлт гаргагч өөрийн хүсэлтээр өргөдлөө эргүүлэн татан авч, 3162 өргөдөл буюу 75.5 хувийг шийдвэрлэж, 666 өргөдлийн үлдэгдэлтэй байна.

Энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал, шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчид гаргасан өргөдөл 241 буюу 6.1 хувиар, шийдвэрлэсэн өргөдөл 311 буюу 10.9 хувиар, үлдэгдэл 10 өргөдлөөр буюу 1.5 хувиар тус тус өсжээ.

График 6.1

Шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчид гаргасан өргөдлийн шийдвэрлэсэн байдал



Шийдвэрлэсэн нийт 3162 өргөдлийн 2288 буюу 72.5 хувьд нь эвлэрэл амжилттай болж, 874 буюу 27.5 хувьд нь эвлэрэл амжилтгүй болжээ. Эвлэрэл амжилттай болсон өргөдлийн шийдвэрлэсэн хэрэгт эзлэх хэмжээ 5.0 хувиар өссөн бол эвлэрэл амжилтгүй болсон өргөдөл мөн 5.0 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Шүүхээс иргэний хэрэг үүсгэсний дараа шилжүүлэн ирсэн 131 иргэний хэргийн 15 хэрэгт эвлэрэл амжилттай болж, 58 нь эвлэрэл амжилтгүй болсон байна.

Харин шүүхээс иргэний хэрэг үүсгэхээс өмнө шилжүүлэн ирсэн нэхэмжлэл өнгөрсөн оны мөн үед 1 байснаас эвлэрэл амжилтгүй болсон бол 2017 оны 1 дүгээр улиралд шүүхээс иргэний хэрэг үүсгэхээс өмнө шилжүүлсэн нэхэмжлэл 2 байснаас 1 нь амжилттай шийдвэрлэгдсэн байна.

График 6.2


Шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчид гаргасан өргөдлийн шийдвэрлэсэн байдал



Шүүхээс иргэний хэрэг үүсгэсний дараа шилжүүлэн ирсэн 131 иргэний хэргийн 4 буюу 3.0 хувьд нь эвлэрэл амжилттай, 7 буюу 5.3 хувьд нь эвлэрэл амжилтгүй болж, 35 хэргийн үлдэгдэлтэй байна.

График 6.3

Иргэний хэрэг үүсгэсний дараа шилжүүлэн ирсэн хэрэг




Нийт үлдэгдэл хэрэг 725 байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 33 хэргээр буюу 4.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Маргааны төрлөөр: Эвлэрүүлэн зуучлагчид нийт 3162 өргөдлийг шийдвэрлэсний 2503 хэрэг буюу 79.3 хувь нь иргэний эрх зүйн маргаан, 637 хэрэг буюу 20.2 хувь нь гэр бүлийн эрх зүйн маргаан, 17 хэрэг буюу 0.6 хувь нь хөдөлмөрийн ганцаарчилсан маргаан байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад иргэний эрх зүйн маргаан 270 хэргээр буюу 12 хувиар, гэр бүлийн эрх зүйн маргаан 87 хэргээр буюу 14.8 хувиар тус тус өссөн бол хөдөлмөрийн ганцаарчилсан маргаан 3 хэргээр буюу 15 хувиар буурчээ.

График 6.4

Эвлэрүүлэн зуучлагчийн шийдвэрлэсэн хэргийн төрөл




Иргэний эрх зүйн нийт 2508 маргааны 2193 буюу 87.5 хувьд нь эвлэрүүлэн зуучлах ажиллагаа амжилттай, 315 буюу 12.5 хувьд нь эвлэрэл амжилтгүй, гэр бүлийн эрх зүйн нийт 637

маргааны 83 буюу 13 хувьд нь эвлэрэл амжилттай, 554 буюу 87 хувьд нь эвлэрэл амжилтгүй, хөдөлмөрийн ганцаарчилсан маргааны хувьд нийт 17 хэрэг шийдвэрлэсний 12 буюу 70.5 хувьд нь эвлэрэл амжилттай, 5 буюу 29.5 хувьд нь эвлэрэл амжилтгүй явагдсан байна. Эндээс иргэний эрх зүйн маргаанд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа амжилттай хэрэгжиж байгаа бол гэр бүлийн эрх зүйн маргааныг эвлэрүүлэн зуучлахад хүндрэлтэй байгаа нь харагдаж байна. Гэр бүлийн эрх зүйн маргааны хувьд эвлэрүүлэн зуучлах ажиллагааг гэрлэлт цуцлахыг хүссэн талуудыг эвлэрүүлэхэд чиглэгдэж байгаа тул ажиллагаа хийхэд бэрхшээлтэй байна.

Харин хөдөлмөрийн ганцаарчилсан маргааны хувьд эвлэрүүлэн зуучлагчид хандахаас илүүтэй шүүхээр маргаанаа шийдвэрлүүлэх хандлага хэвээр байна.

График 6.5

Эвлэрэл амжилттай явагдсан байдал (маргааны төрлөөр)



Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөлийн 2014 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 03 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

МОНГОЛ УЛСЫН ШҮҮХ ДЭХ ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАХ АЖИЛЛАГААНЫ
2017 ОНЫ 1 УЛИРЛЫН ШУУРХАЙ МЭДЭЭ


Монгол улсын нийт шүүх			Иргэний эрх зүйн маргаан	Гэр бүлийн эрх зүйн маргаан	Хөдөлмөрийн ганцаарчилсан маргаан	Урьдчилан шийдвэрлэх журмаар гаргасан өргөдөл, нэхэмжлэл	Бүгд
А		Б	1	2	3	4	5
Шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчид гаргасан өргөдөл /2+3+4+8/		1	3339	568	23	260	4190
Хүлээн авахаас татгалзсан		2	190	8	0	4	202
Буцаасан /хүсэлт гаргагч хүсэлтээ татан авсан/		3	139	17	3	1	160
Шийдвэрлэсэн		4	2508	424	17	213	3162
Үүнээс	Эвлэрэл амжилттай болсон	5	2193	67	12	16	2288
	Эвлэрэл амжилтгүй болсон	6	315	357	5	197	874
Үүнээс: Шүүгчийн захирамжаар баталгаажуулсан		7	1882	50	9	11	1952
Үлдэгдэл		8	502	119	3	42	666
Шүүхээс иргэний хэрэг үүсгэхээс өмнө шилжүүлэн ирсэн нэхэмжлэл /10+11+13/		9	0	2	0	0	2
Үүнээс	Эвлэрэл амжилттай болсон	10	0	1	0	0	1
	Эвлэрэл амжилтгүй болсон	11	0	0	0	0	0
Үүнээс: Шүүгчийн захирамжаар баталгаажуулсан		12	0	1	0	0	1
Үлдэгдэл		13	0	1	0	0	1
Шүүхээс иргэний хэрэг үүсгэсний дараа шилжүүлэн ирсэн иргэний хэрэг /15+16+18/		14	46	61	7	17	131
Үүнээс	Эвлэрэл амжилттай болсон	15	4	7	3	1	15
	Эвлэрэл амжилтгүй болсон	16	7	33	2	16	58
Үүнээс: Шүүгчийн захирамжаар баталгаажуулсан		17	2	2	2	0	6
Үлдэгдэл		18	35	21	2	0	58
Нийт үлдэгдэл /8+13+18/		19	537	141	5	42	725

7. ШҮҮХИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ОРОЛЦОО

Улсын хэмжээнд 2017 оны 1 дүгээр улиралд анхан шатны шүүхэд шүүх бүрэлдэхүүнтэйгээр шийдвэрлэсэн нийт 795 шүүх хуралдаанд 805 иргэдийн төлөөлөгч оролцсон байна. Нийт бүрэлдэхүүнтэй шүүх хуралдааны 517 буюу 65 хувь нь эрүүгийн, 247 буюу 31.1 хувь нь иргэний, 31 буюу 3.9 хувь нь захиргааны хэргийн шүүхийн шүүх хуралдаан байна.

График № 7.1


Бүрэлдэхүүнтэй шүүх хуралдаан



Шүүх хуралдаанд оролцсон нийт 805 иргэдийн төлөөлөгчийн 788 нь нэг иргэдийн төлөөлөгч, 8 нь хоёр иргэдийн төлөөлөгч, 9 нь гурван иргэдийн төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэйгээр оролцсон бөгөөд иргэдийн төлөөлөгчдөд 6 сая 318 мянга 997 төгрөгийн хөлс олгожээ.

График № 7.2

Иргэдийн төлөөлөгчийн насны байдал



2017 оны 1 дүгээр улиралд шүүх хуралдаанд оролцсон 46-55 насны иргэдийн төлөөлөгч 31.1 хувь, 36-45 насны иргэдийн төлөөлөгч 30.7 хувь, 56-аас дээш насны иргэдийн төлөөлөгч 21.3 хувь, 25-35 насны иргэдийн төлөөлөгч 16.9 хувийг тус тус эзэлж байна.

Нийт шүүх хуралдаанд оролцсон иргэдийн төлөөлөгчийн 355 буюу 44.1 хувь нь эрэгтэй, 450 буюу 55.9 хувь нь эмэгтэй байна. Боловсролын түвшингээр нь авч үзвэл, дээд боловсролтой иргэдийн төлөөлөгч 347 буюу 43.1 хувь, бүрэн дунд боловсролтой иргэдийн төлөөлөгч 442 буюу 54.9 хувь, боловсролгүй иргэдийн төлөөлөгч 16 буюу 2 хувийг тус тус эзэлжээ.

Хүснэгт 1

Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн оролцоо

№	Шүүх	Шүүх хуралдааны тоо	Оролцсон иргэдийн төлөөлөгчийн	№	Шүүх	Шүүх хуралдааны тоо	Оролцсон иргэдийн төлөөлөгчийн тоо
1.	Архангай аймаг дахь анхан шатны шүүхүүд	22	22	23.	Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүх	4	4
2.	Баян-Өлгий аймаг дахь анхан шатны шүүхүүд	6	6	24.	Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь сум дундын шүүх	3	3
3.	Баянхонгор аймаг дахь анхан шатны шүүхүүд	9	9	25.	Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь сум дундын шүүх	4	4
4.	Булган аймаг дахь анхан шатны шүүхүүд	12	12	26.	Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь сум дундын шүүх	12	12
5.	Говь-Алтай аймаг дахь анхан шатны шүүхүүд	5	5	27.	Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь сум дундын шүүх	8	10
6.	Говьсүмбэр аймаг дахь анхан шатны шүүхүүд	6	6	28.	Ховд аймгийн Булган сум дахь сум дундын шүүх	2	2
7.	Дархан-Уул аймаг дахь анхан шатны шүүхүүд	30	30	29.	Хэнтий аймгийн Бор-Өндөр сум дахь сум дундын шүүх	7	8
8.	Дорноговь аймаг дахь анхан шатны шүүхүүд	6	6	30.	Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх	25	25
9.	Дорнод аймаг дахь анхан шатны шүүхүүд	12	12	31.	Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	44	44
10.	Дундговь аймаг дахь анхан шатны шүүхүүд	6	10	32.	Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	22	23
11.	Завхан аймаг дахь анхан шатны шүүхүүд	7	7	33.	Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	24	24
12.	Орхон аймаг дахь анхан шатны шүүхүүд	40	40	34.	Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	95	95
13.	Өмнөговь аймаг дахь анхан шатны шүүхүүд	12	12	35.	Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	57	57
14.	Өвөрхангай аймаг дахь анхан шатны шүүхүүд	12	12	36.	Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	78	78

15.	Сүхбаатар аймаг дахь анхан шатны шүүхүүд	11	11	37.	Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	13	13
16.	Сэлэнгэ аймаг дахь анхан шатны шүүхүүд	9	9	38.	Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	11	11
17.	Төв аймаг дахь анхан шатны шүүхүүд	20	20	39.	Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	11	11
18.	Увс аймаг дахь анхан шатны шүүхүүд	7	9	40.	Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	31	31
19.	Ховд аймаг дахь анхан шатны шүүхүүд	6	6	41.	Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	24	24
20.	Хөвсгөл аймаг дахь анхан шатны шүүхүүд	16	16	42.	Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	35	35
21.	Хэнтий аймаг дахь анхан шатны шүүхүүд	9	9	43.	Багануур дүүргийн Эрүү, Иргэний хэргийн анхан шатны шүүх	9	9
22.	Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүх	4	4	44.	Багахангай, Налайх дүүргийн Эрүү, Иргэний хэргийн анхан шатны шүүх	9	9
НИЙТ ДҮН						795	805

Сонгогдсон иргэдийн төлөөлөгчөөс шалтгаалан 19 шүүх хуралдаан хойшилсон байх бөгөөд 3 буюу 15.7 хувь нь өвчтэй, 4 буюу 21.1 хувь нь бага насны хүүхэд асрах чөлөөтэй, 12 буюу 63.2 хувь нь бусад хүндэтгэн үзэх шалтгааны улмаас шүүх хуралдаанд оролцоогүй байна. Иргэдийн төлөөлөгчөөс шалтгаалахгүйгээр хойшилсон шүүх хуралдааны тоо 765 байгаа бөгөөд иргэдийн төлөөлөгчөөс татгалзсан тохиолдол гараагүй байна.

8. ДҮН ШИНЖИЛГЭЭ

Шийдвэрлэсэн хэрэг: Анхан шатны шүүхүүд 2017 оны 1 дүгээр улиралд эрүүгийн 1667, иргэний 10331, захиргааны 425 хэргийг хянан шийдвэрлэсэн байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал хянан шийдвэрлэсэн иргэний хэрэг 302 буюу 3 хувиар, эрүүгийн хэрэг 180 буюу 12.1 хувиар, захиргааны хэрэг 78 буюу 22.5 хувиар тус тус өссөн байна.

Зарим төрлийн гэмт хэргийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад хүнийг санаатай алах гэмт хэрэг 3.4 хувиар, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг 9.8 хувиар, бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг 18.3 хувиар, танхайрах гэмт хэрэг 20.7 хувиар, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэг 30.8 хувиар тус тус өссөн бол хүчиндэх гэмт хэрэг 1.8 хувиар, бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулах гэмт хэрэг 11.8 хувиар, эд зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлэх гэмт хэрэг 28.6 хувиар тус тус буурсан байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хорих ял шийтгүүлсэн хүний тоо 15.3 хувиар, торгох ял шийтгүүлсэн хүний тоо 26.3 хувиар, албадан ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн хүний тоо 0.9 хувиар тус тус өссөн бол баривчлах ял шийтгүүлсэн хүний тоо 21.2 хувиар буурсан байна.

Нийт ял шийтгүүлэгчдийн дотор 9.4 хувь буюу 179 нь эмэгтэй, 6.9 хувь буюу 128 нь насанд хүрээгүй этгээд байна. Энэ үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал ял шийтгүүлсэн эмэгтэйчүүдийн тоо 1.6 дахин, насанд хүрээгүй хүний тоо 1.5 дахин тус тус өссөн байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад цагдан хорих зөвшөөрөл олгосон хүний тоо 16.7 хувиар буурсан бол цагдан хорих зөвшөөрөл олгохоос татгалзсан хүний тоо 12 буюу 17.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Давж заалдах шатны шүүхүүд эрүүгийн 491, иргэний 1086, захиргааны 236 хэрэг хянан шийдвэрлэсэн байна. Давж залдах шатанд эрүүгийн эрүүгийн хэрэг 13.9 хувиар, иргэний хэрэг 33.7 хувиар тус тус өссөн бол захиргааны хэрэг 33.5 хувиар буурсан байна.

Хяналтын шатны шүүх эрүүгийн 67, иргэний 336, захиргааны 109 хэрэг хянан шийдвэрлэсэн байна. Хяналтын шатны шүүхийн хянан шийдвэрлэсэн хэргийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал эрүүгийн хэрэг 14 буюу 17.8 хувиар буурсан бол иргэний хэрэг 46 буюу 15.9 хувиар, захиргааны хэрэг 13 буюу 13.5 хувиар тус тус өссөн байна.

Монгол Улсын шүүхээс 2017 оны 1 дүгээр улиралд улсын тэмдэгтийн хураамжаар 2 тэрбум 540 сая 403 мянга 102 төгрөг, 275 сая 895 мянга 471 төгрөг, захиргааны зөрчлийн торгох арга хэмжээгээр 25 сая 18 мянга 345 төгрөгийг төрийн санд оруулахаар тус тус шийдвэрлэсэн байна.

Шийдвэрийн тогтвортой байдал: Анхан шатны шүүхийн шийдвэр, тогтоолыг давж заалдах шатны журмаар хянан шийдвэрлэсэн байдалд дүн шинжилгээ хийвэл нийт эрүүгийн хэргийг шийдвэрлэсэн шийтгэх тогтоолын 54.2 хувь, иргэний хэргийг шийдвэрлэсэн шийдвэрийн 63.1 хувь, захиргааны хэргийг шийдвэрлэсэн шийдвэрийн 61.5 хувь нь давж заалдах шатанд өөрчлөгдөж, хүчингүй болсон байна. Өнгөрсөн оны мөн үеийн хэрэгт эзлэх хэмжээтэй харьцуулахад эрүүгийн хэрэг 5.7 хувиар буурсан бол иргэний хэрэг 1.9 хувиар, захиргааны хэрэг 6.5 хувиар тус тус өссөн байна.

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүдийн хэргийн үлдэгдэл 28.1 хувиар, захиргааны хэргийн анхан шатны шүүхүүдийн хэргийн үлдэгдэл 7.4 хувиар өссөн бол иргэний хэргийн анхан шатны шүүхүүдийн хэргийн үлдэгдэл 3.5 хувиар буурсан үзүүлэлттэй гарсан байна. Хугацаа хэтэрсэн үлдэгдэл хэргийн хувьд эрүүгийн хэрэг 96.8 хувиар, захиргааны хэрэг 97 хувиар тус тус өссөн бол иргэний хэрэг 6.6 хувиар буурсан байна.

Давж заалдах шатны шүүхийн магадлалыг хяналтын шатны журмаар шийдвэрлэсэн байдалд дүн шинжилгээ хийвэл эрүүгийн хэргийн тогтоол магадлалын 44.8 хувийг, иргэний хэргийн шийдвэр, магадлалын 58.5 хувийг, захиргааны хэргийн шийдвэр, магадлалын 44 хувийг тус тус өөрчилсөн болон хүчингүй болгож шийдвэрлэсэн байна.

Өнгөрсөн оны мөн үеийн хэрэгт эзлэх хувь хэмжээтэй харьцуулахад эрүүгийн хэрэг 5.8 хувиар буурсан бол иргэний хэрэг 11.6 хувиар, захиргааны хэрэг 8.6 хувиар тус тус өссөн байна.

Үүнээс дүгнээд үзэхэд эрүүгийн хэргийн шийдвэрийн тогтвортой байдал давж заалдах болон хяналтын шатандаа тогтмол өсөлттэй буюу эерэг үзүүлэлттэй гарсан байхад иргэн, захиргааны хэргийн шийдвэрийн тогтвортой байдал бууралттай буюу сөрөг гарсан нь анхаарал татаж байна. Иймд иргэн, захиргааны хэргийн шүүхийн өөрчлөгдсөн, хүчингүй болсон шийдвэртэй хэрэгт дүн шинжилгээ хийж цаашид шийдвэрийн тогтвортой байдлыг хангаж ажиллахад анхаарах шаардлагатай байна. Түүнчлэн энэ нөхцөл байдалд тухайн шүүхийн шүүгчийн хэргийн ачаалал, хэргийн ээдрээ төвөгтэй байдал зэрэг хүчин зүйлүүд хэрхэн нөлөөлж байгаа талаар судлан тогтоох нь зүйтэй байна.

Шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчид гаргасан 4190 өргөдлийн 202 буюу 4.8 хувийг хүлээн авахаас татгалзаж, 160 буюу 3.8 хувийг хүсэлт гаргагч өөрийн хүсэлтээр өргөдлөө эргүүлэн татан авч, 3162 өргөдөл буюу 75.5 хувийг шийдвэрлэж, 666 өргөдлийн үлдэгдэлтэй байна.

Шийдвэрлэсэн нийт 3162 өргөдлийн 2288 буюу 72.5 хувьд нь эвлэрэл амжилттай болж, 874 буюу 27.5 хувьд нь эвлэрэл амжилтгүй болжээ. Эвлэрэл амжилттай болсон өргөдлийн шийдвэрлэсэн хэрэгт эзлэх хэмжээ 5.0 хувиар өссөн бол эвлэрэл амжилтгүй болсон өргөдөл мөн 5.0 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн оролцоо: Тайлант хугацаанд 795 шүүх хуралдаанд 805 иргэдийн төлөөлөгч оролцжээ. Нийт бүрэлдэхүүнтэй шүүх хуралдааны 517 буюу 65 хувь нь эрүүгийн, 247 буюу 31.1 хувь нь иргэний, 31 буюу 3.9 хувь нь захиргааны хэргийн шүүхийн шүүх хуралдаан байна.

Шүүх хуралдаанд оролцсон нийт 805 иргэдийн төлөөлөгчийн 788 нь нэг иргэдийн төлөөлөгч, 8 нь хоёр иргэдийн төлөөлөгч, 9 нь гурван иргэдийн төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэйгээр оролцсон бөгөөд иргэдийн төлөөлөгчдөд 6 сая 318 мянга 997 төгрөгийн хөлс олгожээ.

Хянасан:	Ц.Мандах /ШСМСХ-ийн захирал/
	Б.Отгон /ШСМСХ-ийн судалгаа хариуцсан ахлах референт/
Нэгтгэсэн:	П.Ангарагсайхан /ШСМСХ-ийн статистик хариуцсан референт/
	Э.Ганцэцэг /ШСМСХ-ийн статистик хариуцсан референт/
	Д.Аюуш /ШСМСХ-ийн социологич-судлаач/